8.5. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал зэрэг онцгой нөхцөл бий болсны улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол Улсын Их Хурал ээлжит сонгуулийг хойшлуулна.

8.6. Хэрэв энэ хуулийн 8.5-д заасан онцгой нөхцөл Улсын Их Хурал сонгууль товлон зарласан шийдвэр батлан гаргасны дараа бий болсон бол Улсын Их Хурал сонгууль товлон зарласан шийдвэрээ хүчингүй болгож, ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсооно.

8.7. Улсын Их Хурал энэ хуулийн 8.5-д заасны дагуу сонгуулийг хойшлуулсан, эсхүл энэ хуулийн 8.6-д заасны дагуу сонгууль товлон зарласан шийдвэрээ хүчингүй болгож, ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зогсоосон бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл арилсны дараа ээлжит сонгууль товлон зарлахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн⁵ 30.5, 30.6-д заасны дагуу зохицуулна.

9 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

9.1. Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, сонгуульд оролцогч нам, эвсэл болон бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална:

9.1.1. хууль дээдлэх;

9.1.2. ил тод байдлыг хангах;

9.1.3. шударга ёсыг сахих;

9.1.4. маргааныг шуурхай, үндэслэлтэй, шударга шийдвэрлэх;

9.1.5. сонгогчдын эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх.

⁵ Монгол Улсын Их Хурлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



9.2. Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан сонгуулийн хороодоос энэ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлсэн байна.

9.3. Сонгууль зохион байгуулах ажлын ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.

9.4. Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй.

9.5. Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон журмын дагуу сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, түүнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад туслалцаа үзүүлэх эрхтэй.

9.6. Энэ хуулийн 9.2-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 9.4-т заасныг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

10 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

10.1. Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1. сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, түүнчлэн саналын хуудас, бие даан нэр дэвшигчийг дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулах маягт, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн тойргийн болон салбар, хэсгийн хороодын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, санал авах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, программ

хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл болон тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх зардал;

10.1.2.саналын хайрцаг хийх, сонгуулийн хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг тохижуулах зардал;

10.1.3.сонгуулийн тухай хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага хэвлэх, хүргэх зардал;

10.1.4.сонгуулийн тойргийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

10.1.5.сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

10.1.6.нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал;

10.1.7.дахин санал хураах, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал;

10.1.8.сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүний тухайн сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

10.1.9.сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

10.1.10.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

10.1.11.Улсын Их Хурлаас баталсан бусад зардал.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг улсын бүртгэлийн байгууллагаас гаргасан хүн амын тоонд түшиглэн тооцон гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.

10.3.Тойргийн болон салбар, хэсгийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон



нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

10.4.Тойргийн болон салбар, хэсгийн хороодыг ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна.

10.5.Энэ хуулийн 10.1-д заасан зардлын гүйцэтгэлд төрийн аудитын төв болон орон нутгийн байгууллага аудит хийж, дүгнэлт гаргана.

10.6.Энэ хуулийн 10.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 10.4-т заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэрийн хуваарь

11.1. Сонгуулийн нутаг дэвсгэр нь Монгол Улсын нутаг дэвсгэр байна.

11.2. Энэ хуулийн 4.9-д заасан Улсын Их Хурлын 48 гишүүнийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр нь энэ хуулийн 12.1, 12.2-т заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрог /цаашид "тойрог" гэх/-т хуваагдана.

11.3. Тойрог нь сонгуулийн хэсэг /цаашид "хэсэг" гэх/-т хуваагдана.

12 дугаар зүйл. Тойрог, түүнийг байгуулах

12.1. Улсын Их Хурал 26 тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг харгалзан санал авах өдрөөс зургаагаас доошгүй сарын өмнө байгуулж, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.

12.2. Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг

тойрог болгон нэгтгэж болно.

12.3.Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно.

12.4.Сонгуулийн ерөнхий хороо тойргийг өөрчлөх тухай саналыг дараах тохиолдолд Улсын Их Хуралд оруулж болно:

12.4.1.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал;

12.4.2.тойргийн хүн амын тоо нь өмнөх сонгуулиас хойших хугацаанд 20-оос дээш хувиар өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал.

13 дугаар зүйл.Хэсэг, түүнийг байгуулах

13.1.Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнгын оршин суугаа газрын мэдээллийн санг үндэслэн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын 15-ны өдрөөс өмнө байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.

13.2.Нэг хэсэг нь суманд 2000 хүртэл, аймгийн төвд 2500 хүртэл, нийслэлийн дүүрэгт 3000 хүртэл сонгогчтой байна.

13.3.Нэгэнт байгуулагдсан хэсгийн сонгогчдыг онцгой нөхцөлийн улмаас зохион байгуулалттайгаар тухайн хэсгээс тусгаарлах, хэсгийг нэгтгэх, шинээр байгуулах асуудлыг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө шийдвэрлэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ

14 дүгээр зүйл.Сонгуулийн байгууллагын тогтолцоо

14.1.Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь сонгуулийн төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

14.2.Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо, орон нутгийн байгууллага нь сонгуулийн тойргийн хороо /цаашид "тойргийн



хороо" гэх/, тойргийн салбар хороо /цаашид "салбар хороо" гэх/, сонгуулийн хэсгийн хороо /цаашид "хэсгийн хороо" гэх/ байна.

14.3. Сонгуулийн ерөнхий хороо нь улсын хэмжээнд, тойргийн хороо нь тухайн тойрогт хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд, салбар хороо нь тухайн сум, дүүргийн хэмжээнд, хэсгийн хороо нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжид тус тус сонгуулийн үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулна.

14.4. Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмаар ажиллах ба дээд шатны сонгуулийн хорооны хууль ёсны шийдвэрийг доод шатны сонгуулийн хороо заавал биелүүлэх бөгөөд доод шатны сонгуулийн хорооны хууль бус шийдвэрийг дээд шатны сонгуулийн хороо нь хүчингүй болгох эрхтэй.

14.5. Тойргийн болон салбар, хэсгийн хороодын бүрэлдэхүүнд зөвхөн төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулна.

14.6. Сонгуульд оролцогч аль нэг нам, эвслийн төлөөлөл, төрийн улс төрийн албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч нь сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд орохыг хориглоно.

14.7. Тойргийн болон салбар, хэсгийн хороод байгуулагдсан өдрөөс эхлэн Сонгуулийн ерөнхий хороо тойргийн хорооны, тойргийн хороо харьяалах салбар, хэсгийн хороодын үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд тус тусын-бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.8. Тойргийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд, түүнчлэн санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх, бусдыг төлөөлж санал өгөх, зөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмжийн лац, битүүмжлэлийг гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авах зэрэг хууль бус аливаа үйлдэл хийх, зохион байгуулах, бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно.

14.9. Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

14.10. Сонгуулийн хороодоос сонгууль зохион байгуулах,

сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч болон бусад этгээд хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно.

14.11. Сонгууль зохион байгуулах хугацаанд тойргийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

14.12. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага нь сонгууль зохион байгуулахад энэ хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль⁶ болон холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож сонгуулийн зохих шатны хорооноос тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, тэдгээрийн ажилд туслах үүрэгтэй.

14.13. Энэ хуулийн 14.8-д заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах ба уг зөрчил нь тухайн төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

14.14. Энэ хуулийн 14.10-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигч болон бусад этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 14.12-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

14.15. Энэ хуулийн 14.11-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчид холбогдох хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

⁶ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

**15 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хороо, түүний бүрэн эрх**

15.1. Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

16 дугаар зүйл. Тойргийн хороо, түүний бүрэн эрх

16.1. Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.

16.2. Тойргийн хороо нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.2.1. сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

16.2.2. сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

16.2.3. харьяалах салбар болон хэсгийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

16.2.4. харьяалах хэсгийн хороодын нэгдсэн дугаарыг тогтоох;

16.2.5. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах салбар болон хэсгийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

16.2.6. тойрогт нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох;

16.2.7. сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар харьяалах салбар болон хэсгийн хороо, түүнчлэн тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

16.2.8. харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;

16.2.9. санал хураалтын дүнгийн тухай харьяалах салбар



болон хэсгийн хороодын шийдвэрийг үндэслэн тухайн тойргийн сонгуулийн дүнг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;

16.2.10.дахин санал хураах, нөхөн болон дахин сонгууль явуулах ажлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

16.2.11.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгөх;

16.2.12.сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

16.2.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

17 дугаар зүйл.Салбар хороо, түүний бүрэн эрх

17.1.Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

17.2.Салбар хороо нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ хуулийн 16.2.1, 16.2.2, 16.2.7-д заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.2.1.харьяалах хэсгийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

17.2.2.тойргийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах хэсгийн хороонд зохих журмын дагуу хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

17.2.3.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж бичгээр хариу өгөх;

17.2.4.санал хураалтын дүнгийн тухай харьяалах хэсгийн хороодын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн хэмжээгээр сонгуулийн дүнг нэгтгэж, харьяалах тойргийн хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;

17.2.5.дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;



17.2.6. сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, харьяалах тойргийн хороонд хүлээлгэн өгөх;

17.2.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

18 дугаар зүйл. Хэсгийн хороо, түүний бүрэн эрх

18.1. Тойргийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

18.2. Хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын цар хэмжээг харгалзан дор дурдсанаар тогтооно:

18.2.1. тухайн хэсэгт 2000 хүртэл сонгогчтой бол 5, эсхүл 7;

18.2.2. тухайн хэсэгт 2000-2500 хүртэл сонгогчтой бол 7, эсхүл 9;

18.2.3. тухайн хэсэгт 2500-аас дээш сонгогчтой бол 9, эсхүл 11.

18.3. Хэсгийн хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.3.1. хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

18.3.2. сонгогчийг шилжүүлэх, шилжиж ирсэн сонгогчийг бүртгэх тухай асуудлыг улсын бүртгэлийн холбогдох байгууллагад мэдэгдэх;

18.3.3. эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа иргэн сонгогчдын нэрийн жагсаалтад орсон бол улсын бүртгэлийн холбогдох байгууллагад мэдэгдэх;

18.3.4. энэ хуулийн 20.2-т заасан сонгогчийн мэдээлэл түүний иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй зөрсөн тохиолдолд зөрчлийг арилгуулахаар улсын бүртгэлийн холбогдох байгууллагад мэдэгдэх;

18.3.5. санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмж зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

18.3.6.санал хураалтын дүнг гаргаж, салбар хороонд, салбар хороогүй бол тойргийн хороонд нэн даруй хүргэх;

18.3.7.сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, салбар хороонд, салбар хороогүй бол тойргийн хороонд хүлээлгэн өгөх;

18.3.8.сонгууль зохион байгуулах болон санал авах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;

18.3.9.дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

18.3.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

19 дүгээр зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт

19.1.Тойргийн болон салбар, хэсгийн хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хуралдаанд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол тухайн сонгуулийн хорооны хуралдааныг хүчинтэйд тооцно.

19.3.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн энэ хуулийн 19.1-д заасан хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр орхиж гарахыг хориглоно.

19.4.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр орхисон тохиолдолд түүнийг хуралдаанд оролцож тухайн асуудлаар татгалзсан санал гаргасанд тооцно.

19.5.Энэ хуулийн 19.1-д заасан тогтоолд тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

19.6.Энэ хуулийн 19.2-т заасан сонгуулийн хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаас гаргасан тогтоолд тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

19.7.Сонгуулийн хороод хуралдаанаараа дэгээ тогтоон батлах



бөгөөд түүнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тусгасан байна.

19.8. Сонгуулийн хороодын хуралдааны шийдвэрийг нийтэд ил тод мэдээлнэ.

19.9. Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу заавал хөтлөх бөгөөд түүнийг тухайн хорооны нэг гишүүнд хариуцуулна.

19.10. Сонгуулийн баримт бичиг бүртгэлтэй байх бөгөөд түүнд хамаарах баримт бичиг, түүнийг бүртгэх журмыг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

19.11. Тойргийн болон салбар хорооны дарга нь дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

19.12. Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг ажлын шаардлагыг харгалзан үндсэн ажлаас нь түр чөлөөлөн ажиллуулах ба түүнд энэ хугацааны цалин хөлсийг үндсэн байгууллагаас нь олгоно.

19.13. Хуульд өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийн талаар дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

19.14. Сонгуулийн хороод сонгууль зохион байгуулахтай холбогдсон, түүнчлэн хууль зөрчсөн тухай асуудлыг шалгуулах, эсхүл зөрчлийг таслан зогсоох асуудлаар сонгуулийн тухай хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн аливаа байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэж, бичгээр хариу мэдэгдэнэ.

19.15. Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан хувь хүн, хуулийн этгээдтэй сонгон шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ба энэхүү үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн⁷ зохицуулалтад хамаарахгүй.

19.16. Сонгуулийн хороодоос бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

шийдвэрийг сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу үүрэг хүлээсэн тухайн нутаг дэвсгэрийн бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

19.17.Энэ хуулийн 19.9-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 19.13-т заасан хугацаанд хариу мэдэгдээгүй сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, 19.14-т заасан хугацаанд хариу мэдэгдээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 19.16-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

19.18.Энэ хуулийн 19.6-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах ба уг зөрчил нь тухайн төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах

20.1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэл, мэдээллийн улсын санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

20.2. Сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэл бүхий сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын



хаягийг бүртгэх бөгөөд ийнхүү бүртгэхдээ сонгогчийн нэрийг оршин суугаа газрын хаягаар нь дараалуулан бичнэ.

20.3. Аймаг, нийслэл дэх улсын бүртгэлийн салбар, нэгж нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны хүн амын хаягийн бүртгэлийг үндэслэн сум, дүүрэг, хорооны улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтны гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

20.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.3-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор болон энэ хуулийн 13.1-д заасны дагуу байгуулсан хэсэг нэг бүрээр нь нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын 15-ны өдрөөс өмнө сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байрлуулна.

20.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгуулийн эрх бүхий иргэнийг энэ хуулийн 20.4-т заасан цахим хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалт дахь зөвхөн өөрт нь холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

20.6. Улсын дээд шүүх эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хорих газарт ял эдэлж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг тус тус гаргаж улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын 10-ны өдрөөс өмнө хүргүүлнэ.

20.7. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ:

20.7.1. сонгогчоос энэ хуулийн 20.4-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;

20.7.2. сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт зэрэг иргэний бүртгэлтэй холбогдсон өөрчлөлт;

20.7.3.нас барсан иргэний бүртгэлтэй холбогдсон өөрчлөлт;

20.7.4.энэ хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлт.

20.8.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 20.7-д заасны дагуу ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг тойрог тус бүрээр ангилах бөгөөд тойрог бүрд хамрагдах сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр гаргаж, санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө холбогдох тойргийн хороонд хүргүүлнэ.

20.9.Тойргийн хороо энэ хуулийн 20.8-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтаар тухайн тойрогт харьяалагдах хэсэг бүрээр ангилсан цахим мэдээллийн сан үүсгэж, санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

20.10.Тухайн хэсгийн харьяа нутаг дэвсгэрт байрлаж байгаа цэргийн анги, салбарын захирагч нь тухайн байгууллагад алба хааж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг, цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга нь захиргааны зөрчил болон байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу тус тус гаргаж, санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө харьяа хэсгийн хороонд хүргүүлнэ.-

20.11.Хэсгийн хороо энэ хуулийн 20.9-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20.10-т заасан сонгуулийн насны иргэдийн мэдээлэлтэй тулган хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

20.12.Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сонгуулийн ерөнхий хороо хамтран батална.

20.13.Сонгогч энэ хуулийн 20.4, 20.11-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.

20.14.Хэсгийн хороо энэ хуулийн 20.11-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоог тойргийн хороонд, тойргийн хороо



хэсгийн хороодоос ирүүлсэн сонгогчдын тоог нэгтгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

20.15. Сонгогчдын нэрийн жагсаалт нь үндсэн ба зөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах жагсаалтаас бүрдэнэ.

20.16. Сонгогчийг зөвхөн сонгуулийн нэг хэсэгт сонгогчдын нэг нэрийн жагсаалтад бүртгэнэ.

20.17. Хэсгийн хорооны албан ажлын хэрэгцээнд болон сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно.

20.18. Энэ хуулийн 20.17-д заасны дагуу хүсэлт гаргасан нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасаар болон цахим хэлбэрээр хувилж олшруулах зардлыг тус тус хариуцах бөгөөд тухайн зардлын хэмжээг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

20.19. Энэ хуулийн 20.3-20.7, 20.10, 20.16-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 20.8, 20.9, 20.11, 20.14-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 20.17-д заасныг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

20.20. Энэ хуулийн 20.19-д заасан зөрчил нь ноцтой бол тухайн албан тушаалтныг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

21 дүгээр зүйл. Сонгогчийн бүртгэлийн талаарх гомдлыг шийдвэрлүүлэх журам

21.1. Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн байвал энэ тухай сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.

21.2. Улсын бүртгэлийн холбогдох байгууллага нь энэ хуулийн 21.1-д заасны дагуу гомдол хүлээн авсан бол тухайн гомдол гаргасан иргэний

мэдээллийг иргэний бүртгэл, мэдээллийн улсын сангаас хайлт хийн тодорхойлж, лавлагаа гаргах ба тухайн лавлагааг үндэслэн сонгогчийн мэдээллийг хэсгийн хорооны дэргэд ажиллах иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гурав хоногийн дотор сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулна.

21.3.Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно.

21.4.Санал авах өдөр энэ хуулийн 21.1, 21.2-т заасан ажиллагааг хийхийг хориглоно.

21.5.Энэ хуулийн 21.2-21.4-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22 дугаар зүйл. Сонгогч шилжих

22.1.Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгнө.

22.2.Сонгогчийн шилжилтийг санал авах өдрөөс 30 хоногийн өмнө зогсоох бөгөөд хэсгийн хороо санал авах өдрөөс 30 хоногийн дотор аливаа сонгогчийн шилжилтийг бүртгэхийг хориглоно.

22.3.Сонгогч санал авах өдрөөс 30 хоногийн өмнө шилжих бол албан ажил, эрүүл мэндийн зэрэг үндэслэл бүхий хүсэлтээ өөрийн байнга оршин суугаа газрын харьяа хэсгийн хороонд бичгээр гаргах бөгөөд хэсгийн хороо энэ тухай улсын бүртгэлийн холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

22.4.Энэ хуулийн 22.3-т заасны дагуу шилжсэн сонгогч шилжин очсон газрынхаа хэсгийн хороонд шилжин ирсэн тухайгаа мэдэгдэх бөгөөд энэ тухай хэсгийн хороо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

22.5.Улсын бүртгэлийн холбогдох байгууллага энэ хуулийн 22.3, 22.4-т заасан хэсгийн хорооны мэдэгдлийн дагуу шилжсэн сонгогчийг тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах ба шилжин ирсэн сонгогчийг тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэнэ.

22.6.Иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг сонгууль товлон зарласан өдрөөс эхлэн санал хураалт дуустал улсын хэмжээгээр түр зогсооно.

22.7.Энэ хуулийн 22.2-22.4-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны



дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 22.5, 22.6-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ

23 дугаар зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

23.1. Сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй.

23.2. Хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд эвсэл болон оролцож болох ба энэ тохиолдолд энэ хуулийн 23.1 дэх хэсгийн заалт эвсэлд нэгдэн орж байгаа нам тус бүрд адил хамаарна.

23.3. Нам, эвсэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай⁸, Захиргааны хариуцлагын тухай хууль⁹, Эрүүгийн хууль¹⁰, бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө сонгуульд оролцох хүсэлтийн хамт санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлнэ.

23.4. Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтдээ дараах баримт бичгийг хавсарган Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

23.4.1. нам дангаараа оролцох бол намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллагын шийдвэр, эвсэл байгуулж оролцох бол энэ хуулийн 24.6-д заасан эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;

23.4.2. намын буюу эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дүрмийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

⁸ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Захиргааны хариуцлагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Эрүүгийн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

23.4.3.нам, эвслийн сонгуулийн батлагдсан мөрийн хөтөлбөр;

23.4.4.энэ хуулийн 34.5-д заасан төрийн аудитын байгууллагын дүгнэлт;

23.4.5.сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн нам буюу эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

23.4.6.нам, эвслийн сонгууль эрхлэх төв байгууллагын нэр, түүний бүрэлдэхүүн, байрлах газрын хаяг, харилцах утасны дугаар зэргийг агуулсан мэдээлэл.

23.5.Эвслийг төлөөлөх байгууллага нь энэ хуулийн 23.4-т зааснаас гадна дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

23.5.1.эвслийн гэрээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

23.5.2.эвсэлд нэгдэн орсон нам тус бүрийн удирдах дээд байгууллагын энэ хуулийн 24.1-д заасан хуралдааны шийдвэр, тэмдэглэл.

24 дүгээр зүйл.Намууд эвсэл байгуулах, эвслийн гэрээ

24.1.Энэ хуулийн 23.1-д зааснаар Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намууд Улсын Их Хурлын тухайн ээлжит сонгуульд эвсэл байгуулж оролцох бол түүнд нэгдэн орох нам тус бүр өөрийн Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдааныг хийж, дараах асуудлыг шийдвэрлэнэ:

24.1.1.эвслийн нэр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

24.1.2.эвсэлд нэгдэн орох нам тус бүрд ногдох нэр дэвшигчдийн тоог тогтоох;

24.1.3.нам тус бүр өөрт ногдсон тоонд багтаан нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

24.1.4.цаашид сонгуультай холбогдсон асуудлаар эвсэлд тухайн намыг төлөөлөн шийдвэр гаргах эрхтэйгээр оролцох эрх бүхий төлөөлөгчид /цаашид "намыг төлөөлөх байгууллага" гэх/-ийг томилох;

24.1.5.эвслийн гэрээг хэлэлцэх.



24.2.Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага нь энэ хуулийн 24.1.3-т заасан асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

24.3.Эвсэлд нэгдэн орох намууд тус бүрдээ энэ хуулийн 24.1-д заасан асуудал тус бүрийг шийдвэрлэж, нэгдсэн тохиролцоонд хүрсэн бол эвслийг албан ёсоор байгуулагдсанд тооцох бөгөөд эвслийн гэрээнд нэгдэн орсон намуудын дарга нар гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулна.

24.4.Эвсэл албан ёсны нэр, бэлгэдэлтэй байх бөгөөд түүнийг хувь хүн, улс, үндэстэн, овгийн нэрээр болон өмнөх сонгуульд өөр намуудын эвслийн хэрэглэсэн нэрээр нэрлэхийг тус тус хориглох ба нэгэнт зарлагдсан эвслийн нэрийг сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

24.5.Энэ хуулийн 24.1, 24.3-т заасны дагуу нэгэнт байгуулагдсан эвсэлд, түүнчлэн энэ хуулийн 25.5-д заасны дагуу эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлснээс хойш сонгуулийн явцад аль нэг нам, эвсэл нэгдэн орохыг хориглоно.

24.6.Эвслийг төлөөлөх байгууллага нь эвсэлд нэгдэн орсон нам бүрээс энэ хуулийн 24.1.4-т заасны дагуу томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, гэрээнд өөрчлөлт оруулах, эвслийн нэрийн жагсаалтаар нэр дэвшигчдийн дарааллыг тогтоох, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд зэрэг улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, эвслийн гэрээг цуцлах зэргээр сонгууль болон эвсэлтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх боловч энэ хуулийн 24.1.2-т заасны дагуу намуудад ногдсон суудлын тоог өөрчлөх эрхгүй.

24.7.Эвслийн гэрээнд талуудын нийтлэг болон харилцан хүлээх эрх, үүрэг, эвслийн нэр, эвслийг төлөөлөх байгууллага, түүний удирдах бүрэлдэхүүнд орсон иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүнийг төлөөлөх албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр болон харилцан тохиролцсон бусад асуудлыг тусгана.

24.8.Эвслийн гэрээ нь тухайн сонгууль, түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

24.9.Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит болон нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд



нэг этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд оролцохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ.

24.10.Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд түүний энэ хуулийн 24.1-д заасан байгууллага нь энэ хуулийн 24.6-д заасан төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг тарсан гэж үзнэ.

24.11.Энэ хуулийн 24.1.4-т заасан намыг төлөөлөх байгууллага эвслийн гэрээг хэдийд ч цуцалж болно.

24.12.Энэ хуулийн 24.9-24.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн бүрэлдэхүүнд орж байсан намууд дахин нэгдэж эвсэл байгуулах, түүнчлэн Улсын Их Хуралд нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглоно.

24.13.Анхнаасаа эвсэлд нэгдээгүй намууд, түүнчлэн энэ хуулийн 24.9-24.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн Засгийн газар байгуулахаас бусад тохиолдолд дахин нэгдэж эвсэл байгуулах, мөн нэгдсэн нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглох бөгөөд энэ заалт нь эвслээс гарсан нам наймаас дээш суудалтай бол дангаараа бүлэг байгуулахад хамаарахгүй.

25 дугаар зүйл. Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх

25.1. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэхдээ тэдгээрийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

25.2. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичгийг үндэслэн тэдгээрийг хүлээн авснаас хойш тав хоногт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

25.3. Дараах тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзана:

25.3.1. нам буюу эвсэлд нэгдэн орсон намуудын аль нэг



нь энэ хуулийн 23.1-д заасан шаардлага хангаагүй бол;

25.3.2.энэ хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;

25.3.3.энэ хуулийн 23.4, 23.5-д заасан баримт бичгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаа дууссанаас хойш ирүүлсэн бол;

25.3.4.энэ хуулийн 34.3, 34.4-т заасныг зөрчсөн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө энэ хуулийн 25.4-т заасан хугацаанд хуулийн шаардлагад нийцүүлж ирүүлээгүй бол;

25.3.5.эвсэл байгуулах тухай шийдвэр гаргахдаа энэ хуулийн 24.1-24.4-т заасан журам, шаардлагыг зөрчсөн бол;

25.3.6.эвсэлд нэгдэн орсон аль нэг нам нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлсэн бол.

25.4.Сонгуулийн ерөнхий хороо төрийн аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 34.3, 34.4-т заасан шаардлагад нийцээгүй сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тухайн нам, эвсэлд буцаах бөгөөд нам, эвсэл энэ хуулийн 34.3, 34.4-т заасан шаардлагад нийцүүлж сонгуулийн мөрийн хөтөлбөрөө гурав хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

25.5.Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

26 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам

26.1.Сонгуульд оролцох нам, эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 20 хоногийн дараа эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.

26.2.Сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 15 хоногийн дараа эхлүүлж, 12 хоногийн хугацаанд дуусгана.

26.3.Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их

Хурлын гишүүнд нэр дэвшигчээр бүртгүүлж, Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч гэж үзнэ.

26.4.Нэр дэвшигч нь энэ хуулийн 6.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

26.4.1.банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өр болон хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөргүй байх;

26.4.2.ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2, 78.3-т заасны дагуу ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх;

26.4.3.цэргийн жинхэнэ хугацаат алба хаах насны иргэн Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн¹¹ дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлсэн байх.

26.5.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө 27 нас хүрсэн иргэнд энэ хуулийн 26.4.3 дахь заалт хамаарахгүй.

26.6.Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.

26.7.Нэг намын гишүүнийг нөгөө намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг тус тус хориглоно.

26.8.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшиж болохгүй.

26.9.Нам, эвсэл аливаа нэг намын гишүүн бус иргэнийг түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр нэрийг нь дэвшүүлж болно.

26.10.Нэр дэвшигч нь тойрогт нэр дэвших, эсхүл нэрийн жагсаалтаар нэр дэвшихийн аль нэгийг нь сонгож зөвшөөрөх бөгөөд эрх бүхий байгууллага энэ асуудлаар нэгэнт шийдвэр гаргасан бол түүнийг дахин өөрчлөхийг санал хураалт дуустал хориглоно.

¹¹ Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 3 дугаарт нийтлэгдсэн.



26.11.Энэ хуулийн 26.6-д зааснаар төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэн төрийн албанд эргэж ороход Төрийн албаны тухай хуулийн¹² 17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

27 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх

27.1. Нам, эвсэл Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг тухайн нам, эвслийн гаргасан дарааллын дагуу нэрийн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.

27.2. Нам, эвслээс энэ хуулийн 27.1-д заасны дагуу нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна.

27.3. Нам, эвсэл тойрогт нэр дэвшүүлэхдээ тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ.

27.4. Намаас нэр дэвшүүлэх асуудлыг Улс төрийн намын тухай хуулийн¹³ 13.7-д заасны дагуу тухайн намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдаанаар хэлэлцэж, нууцаар санал хурааж, ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэнэ.

27.5. Нам нэр дэвшүүлэхдээ энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан нийтлэг журмаас гадна дор дурдсан журмыг баримтална:

27.5.1. энэ хуульд заасан шаардлагыг хангасан тухайн намын гишүүнийг намынхаа дүрмийг баримтлан намын анхан шатны байгууллагаас эхлэн нэр дэвших, сонгогдох адил тэгш боломж олгох үндсэн дээр шалгаруулах;

27.5.2. нэр дэвшүүлэхдээ тухайн хүний Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс, хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх;

27.5.3. энэ хуулийн 27.5.1-д заасны дагуу нэр дэвшүүлэхдээ эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаа явуулахыг хориглох;

27.5.4. энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтыг

¹² Төрийн албаны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Улс төрийн намын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэл 2005 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

гаргахдаа эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг тойргийн дарааллаар, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1, 27.4-т заасан хуралдаанаар нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, хувиар нь эрэмбэлэн дараалалд оруулах;

27.5.5.нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэсэн хуралдааны шийдвэрт намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага, түүнчлэн эвслийг төлөөлөх байгууллага, гишүүдийн тоо, хуралдаанд оролцсон гишүүдийн ирц, нам, эвслээс нэр дэвшиж байгаа хүн бүрийн авсан саналын тоо, хувь, нэр дэвшиж байгаа хүн энэ хуульд заасан болзол, шаардлагыг хангасан талаар тусгах.

27.6.Эвслээс нэр дэвшүүлэхэд энэ хуулийн 24.1.2, 24.1.3, 24.2, 24.6, 27.5-д заасан журмыг баримтална.

27.7.Нам, эвсэл нэр дэвшүүлэх асуудлаар энэ хуульд нийцүүлэн өөрсдийн дотоодод мөрдөх журмыг тогтоон мөрдүүлнэ.

28 дугаар зүйл.Бие даан нэрээ дэвшүүлэх

28.1.Энэ хуулийн 7.2-т заасан бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 11.2-т заасан тойрогт нэрээ дэвшүүлнэ.

28.2.Бие даан нэрээ дэвшүүлэгч энэ хуулийн 7.2-т заасан тооны дэмжигч-сонгогчдын гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу зуруулсан байна.

28.3.Тойргийн хороо энэ хуулийн 28.2-т заасан маягтыг бие даан нэрээ дэвшүүлэгчид тэмдэг дарж олгоно.

28.4.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 28.2-т заасан дэмжигч-сонгогчдын гарын үсгийг авахдаа тухайн тойрогт хамрагдах аймаг, дүүрэг бүрийн сонгогчдын төлөөллийг оролцуулсан байна.

28.5.Энэ хуулийн 28.2-т заасан маягтад дэмжигч-сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг гаргацтай, тодорхой бичсэн байна.

29 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг бүртгэх

29.1.Тойргийн хороо тойрогт нэр дэвшигчийг, Сонгуулийн ерөнхий хороо тойрогт нэр дэвшигчээс бусад нам, эвслээс нэр дэвшигчийг тус тус бүртгэнэ.



29.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь энэ хуулийн 26.1-д заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш тав хоногийн хугацаанд багтаан тойрогт нэр дэвшигчтэй холбогдсон дараах баримт бичгийг тойргийн хороонд ирүүлнэ:

29.2.1.нэр дэвшүүлсэн тухай шийдвэр, тэмдэглэл;

29.2.2.нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт, нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;

29.2.3.нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг;

29.2.4.энэ хуулийн 26.4.1-д заасан өр төлбөргүй болох тухай нэр дэвшигчийн мэдүүлэг, эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

29.2.5.энэ хуулийн 26.4.2-т заасныг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

29.2.6.энэ хуулийн 26.6-д заасан этгээдийн тухайд төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

29.2.7.нэр дэвшигчийн намтар.

29.3.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь энэ хуулийн 29.2-т заасан хугацаанд багтаан тойрогт нэр дэвшигчдээс бусад нам, эвслээс нэр дэвшигчтэй холбогдсон энэ хуулийн 29.2.1-29.2.7-д заасан баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

29.4.Нам, эвсэл нь тойрогт нэр дэвшигчдийн энэ хуулийн 29.2-т заасан баримт бичгийг тойргийн хороонд хүргүүлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлсэн шийдвэр, нийт нэр дэвшигчийн жагсаалт, нэр дэвшүүлсэн хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн байна.

29.5.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 26.2-т заасан хугацаанд багтаан энэ хуулийн 29.2.3-29.2.7-д заасан баримт бичиг болон дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягт, нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдлийн хамт тойргийн хороонд ирүүлнэ.

29.6.Энэ хуулийн 29.2.4-т заасан тодорхойлолтыг Улсын дээд шүүх, энэ хуулийн 29.2.5-д заасан тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллага нэр дэвшигч тус бүрээр гаргаж, Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороонд сонгууль товлон зарласан өдрөөс хойш 35 хоногийн дотор албан бичгээр хүргүүлнэ.

29.7.Энэ хуулийн 29.2.4, 29.2.7-д заасан баримт бичгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

29.8. Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэхдээ нам, эвсэл болон нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

29.9. Тойргийн хороо бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын мэдээлэл үнэн зөв эсэхийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан сонгогчдын нэрийн жагсаалт, оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй түүвэрлэн тулгах буюу шаардлагатай бол тухайн иргэнтэй уулзаж нягтлан шалгах бөгөөд уг ажлыг салбар хороогоор, салбар хороогүй бол хэсгийн хороогоор гүйцэтгүүлж болно.

29.10. Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо энэ хуулийн 29.2-29.4-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор нэр дэвшигчээр бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

29.11. Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо дараах тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзана:

29.11.1. энэ хуулийн 26.1, 26.2-т заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй;

29.11.2. энэ хуулийн 26.4, 26.6-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;

29.11.3. энэ хуулийн 26.7-д заасныг зөрчиж, өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн;

29.11.4. нэр дэвшүүлэх ажиллагаа энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг зөрчиж явагдсан бол нийт нэр дэвшигчийг;

29.11.5. энэ хуулийн 29.2, 29.3, 29.5-д заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;

29.11.6. бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журам зөрчсөн, түүнчлэн дэмжигч-сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа бусдыг төлөөлүүлэх, хүч хэрэглэх, хуурч мэхлэх, заналхийлэх, эд мөнгөөр татах, сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус арга хэрэглэсэн, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооноос баталснаас өөр маягтаар гарын үсэг цуглуулсан;

29.11.7. энэ хуулийн 26.8-д заасныг зөрчиж нэр дэвшсэн;

29.11.8. энэ хуулийн 35.15-д заасныг зөрчиж сонгогчийн



саналыг татах зорилгоор арга хэмжээ зохион байгуулсан;

29.11.9.бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуулийн 34.3-т заасан шаардлагад нийцээгүй бол.

29.12.Энэ хуулийн 29.11-д заасан үндэслэл байхгүй бол Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гаргана.

29.13.Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо тус тусын бүртгэсэн нэр дэвшигчид Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн үнэмлэх олгоно.

29.14.Нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороо, эсхүл тойргийн хороонд бүртгүүлж Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн үнэмлэх авснаас хойш өөрөө нэр дэвшигчээс татгалзахыг хориглоно.

29.15.Нэр дэвшигчийг бүртгэх хугацаа дууссанаас хойш тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ ажлын гурван өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

29.16.Сонгуулийн ерөнхий хороо, эсхүл тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд нам, эвсэл санал авах өдрөөс 20 хоногийн өмнө зөрчлийг арилгасны үндсэн дээр нэр дэвшигчийг дахин бүртгүүлэх хүсэлтээ уламжлах, эсхүл энэ хуульд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлж болно.

29.17.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 29.12-т заасан шийдвэр гарснаас хойш ажлын зургаан өдрийн дотор нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалтыг тойрог болон улсын хэмжээнд нэгтгэж, нийтэд мэдээлнэ.

29.18.Энэ хуулийн 29.2, 29.3, 29.5-д заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, эсхүл энэ хуулийн 29.11-д заасан үндэслэл нэр дэвшигч бүртгэгдсэний дараа тогтоогдсон бол нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

29.19.Энэ хуулийн 29.11-д заасныг зөрчиж нэр дэвшигчийг

бүртгэсэн нь тухайн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэл болно.

29.20.Энэ хуулийн 29.11-д заасан зөрчил байгааг мэдсэн боловч нуун дарагдуулсаны улмаас нэр дэвшигчийг бүртгэсэн бол гэм буруутай сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

29.21.Энэ хуулийн 29.20-д заасны дагуу захиргааны хариуцлага хүлээсэн буруутай этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих сонгуулийн хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

30 дугаар зүйл.Нөхөн нэр дэвшүүлэх

30.1.Нам, эвслээс нэр дэвшигч нас барсан, эсхүл шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам, эвсэл нь өөр хүнийг нөхөн нэр дэвшүүлэх шийдвэрээ зохих шатны сонгуулийн хороонд санал авах өдрөөс 20 хоногийн өмнө ирүүлж, энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан журмын дагуу бүртгүүлж болно.

30.2.Нам, эвсэл энэ хуулийн 30.1-д зааснаас бусад тохиолдолд нөхөн нэр дэвшүүлэхийг хориглоно.

31 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах

31.1.Нэр дэвшигч энэ хуулийн 29.12, 29.13-т заасны дагуу бүртгүүлж, 29.17-д заасны дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасах талаарх энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасан Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хорооны шийдвэрийн талаар маргаан гарвал энэ хуулийн 11 дүгээр бүлэгт заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ.

32 дугаар зүйл.Нэр дэвшигчид туслах

32.1.Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгогчидтойгоо уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэрэг сонгуулийн сурталчилгааны болон бусад ажилд нь нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч тусална.



32.2. Тойрогт нэр дэвшигчдээс бусад нам, эвслээс нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг тухайн нам, эвсэл нийт нэр дэвшигчийнхээ өмнөөс бүхэлд нь эрхлэн явуулна.

32.3. Нэр дэвшигчийн шадар туслагч 500 сонгогч тутамд нэгээс илүүгүй, ухуулагч 200 сонгогч тутамд нэгээс илүүгүй байна.

32.4. Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан болон тойрогт нэр дэвшигчдээс бусад нам, эвслээс нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг, тойргийн хороо тойрогт нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг тус тус бүртгэж, үнэмлэх олгоно.

32.5. Энэ хуулийн 32.1-д заасан ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллана.

32.6. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч нь сонгуулийн аль нэг хорооны гишүүн байхыг хориглоно.

32.7. Энэ хуулийн 32.3-т заасныг зөрчиж нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг бүртгэж, үнэмлэх олгосон сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 32.6-д заасныг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

32.8. Энэ хуулийн 32.7-д заасны дагуу захиргааны хариуцлага хүлээсэн гэм буруутай этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд энэ хуулийн 32.3-т заасныг зөрчиж илүү олгосон үнэмлэхийг нь хүчингүй болгоно.

33 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

33.1. Нам, эвсэл болон нэр дэвшигч нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн мөрийн хөтөлбөрөө тайлбарлан таниулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгуулийн сурталчилгаа хийх, холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

33.2. Гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд

шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

33.3.Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

33.4.Энэ хуулийн 33.1-д заасан эрхээ эдлэхэд нь санаатайгаар саад учруулсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 33.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчаас бусад албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 33.3-т заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвсэл, хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

33.5.Энэ хуулийн 33.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчид холбогдох хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ **СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА**

34 дүгээр зүйл. Сонгуулийн мөрийн хөтөлбөр

34.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

34.2.Нам, эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

34.3.Энэ хуулийн 34.1-д заасан сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын



тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх, түүнчлэн үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, эсхүл ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглоно.

34.4. Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд¹⁴ заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна.

34.5. Нам, эвсэл сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

34.6. Сонгуульд олонхи суудал авсан нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь тухайн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлаас байгуулах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болно.

34.7. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан байна.

34.8. Энэ хуулийн 34.2, 34.3-т заасныг зөрчсөн нь тухайн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд уг шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо нийтэд мэдээлнэ.

35 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаа

35.1. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаагаа энэ хуулийн 29.12, 29.13-т заасны дагуу нэр дэвшигч бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлүүлнэ.

35.2. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалаа тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг дэмжин сурталчлах ажлыг уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах, сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулах зэрэг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр зохион байгуулах эрхтэй.

35.3. Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө

¹⁴ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно.

35.4. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хорин хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, арван хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг арван хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

35.5. Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан тус бүр хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

35.6. Энэ хуулийн 35.4, 35.5-д заасан хязгаарлалтын дүнг хэвлэмэл байдлаар сонгогчдод тараах тухайн төрлийн хэвлэлийн нийлбэрээр тооцно.

35.7. Сонгуулийн сурталчилгааны уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал, самбарыг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон тоо, хэмжээний хязгаарыг баримтлан гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулах байршлыг нам, эвсэл, нэр дэвшигчдийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний дотор тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

35.8. Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлэг /цаашид "сурталчилгааны нэвтрүүлэг" гэх/-ийг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлэх ба төлбөртэй нэвтрүүлэхийг хориглоно.

35.9. Сонгуулийн ерөнхий хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлахдаа нам, эвсэл бүрд, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа бие даан нэр дэвшигч бүрд тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэр гаргаж мөрдүүлнэ.

35.10. Энэ хуулийн 35.9-д заасан сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно.

35.11. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.



35.12.Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ.

35.13.Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 35.11-д заасан радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх журмыг хамтран баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

35.14.Энэ хуулийн 35.11-д заасан радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхэд энэ хуулийн 35.9, 35.10-т заасан зарчмыг баримтална.

35.15.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

35.15.1.сонгогчид мөнгө, эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэйгээр үзүүлэх, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах;

35.15.2.биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт зохион байгуулах, түүнийг ивээн тэтгэх, хүлээн авалт, даяллага, цайллага зэрэг сонгуулийн сурталчилгаатай холбогдсон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;

35.15.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;

35.15.4.хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах;

35.15.5.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, аман хэлцэл хийх, хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах.

35.16.Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа энэ хуулийн 35.15.2-т хамаарахгүй.

35.17.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаатай холбогдсон гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн

зөвлөгөө, тусламж, дэмжлэгийг шууд болон шууд бус хэлбэрээр авахыг хориглоно.

35.18.Нам, эвсэл, нэр дэвшигч болон нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчаас сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

35.18.1.энэ хуулийн 35.3-т заасан хугацаанаас хойш санал хурааж дуустал аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх, түүнчлэн санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд санал асуулга явуулах, дүнг хэвлэн нийтлэх, тараах;

35.18.2.нам, эвслээс нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

35.18.3.төрийн болон бусад өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын чанартай ажил, үйлчилгээ явуулах;

35.18.4.энэ хуулийн 35.4, 35.5-д зааснаас илүү материал тараах;

35.18.5.сурталчилгааны уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлалыг барилгын хана, орц, хашаа, гэрлийн шон зэрэг энэ хуулийн 35.7-д зааснаас өөр газарт байрлуулах;

35.18.6.энэ хуулийн 35.8-35.12-т заасныг зөрчиж сурталчилгаа явуулах;

35.18.7.оройн 23.00 цагаас дараа өдрийн өглөөний 10.00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;

35.18.8.сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

35.18.9.шашны зан үйл ашиглах;

35.18.10.сонгогчдын саналыг татах зорилгоор өөрөө болон бусдаар дамжуулан, эсхүл хүмүүнлэгийн, буяны, шашны байгууллага болон төрийн бус байгууллага, сангийн нэрээр халхавчлан сонгогч, түүний гэр бүлийн гишүүн, насанд хүрээгүй иргэн, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, түүнчлэн цалин хөлс, тэтгэлэг олгох;



35.18.11.сонгогчдын саналыг татах зорилгоор төлбөргүйгээр буюу хөнгөлөлттэй үнээр ахуйн болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг явуулах;

35.18.12.сонгогчдын саналыг татах зорилгоор биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулах, түүнийг ивээн тэтгэж оролцох;

35.18.13.сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, дайллага, цайллага, сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;

35.18.14.хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалтын үр дүнг нь хэвлэн нийтлэх, тараах, сурталчлах;

35.18.15.төрийн байгууллага, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг төлбөртэй буюу төлбөргүйгээр сурталчилгааны материал хэвлэх, олшруулах, тээвэрлэх зэрэг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

35.18.16.сонгуулийн сурталчилгаанд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч аливаа хэлбэрээр оролцох, түүнчлэн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч болон насанд хүрээгүй иргэнийг татан оролцуулах;

35.18.17.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон амлалтыг нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах, амаар болон өөр хэлбэрээр сонгогчдын дунд түгээн дэлгэрүүлэх;

35.18.18.сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах.

35.19.Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөрийнхөө хүрээнд хийсэн ажлын тайлангаа иргэд, сонгогчдод сонин, сэтгүүл болон бусад хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх нь энэ хуулийн 35.18-д үл хамаарна.

35.20.Нам, эвсэл, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч нь

сонгуулийн сурталчилгаандаа аливаа шашны сургаал, жаяг дэгийн дагуу үйлддэг хурал хуруулах, сан тавиулах, майдар эргэх, жасаа уншуулах, даллага авахуулах, тахилга мөргөл үйлдүүлэх, овоо тахих зэрэг үйлдэл, үйл ажиллагааг зохион байгуулсан, түүнд оролцсон, ийм арга хэмжээг санхүүжүүлсэн, шашны эд өглөгийн зүйл, хэрэгсэл тараасан бол шашны зан үйл ашигласан гэж үзнэ.

35.21.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгасан иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр, сүм хийдийн харилцаа, шашны талаарх бодлого, үзэл баримтлалыг сонгогчдод тайлбарлан таниулах үйл ажиллагааг энэ хуулийн 35.20-д заасан үйлдэл гэж үзэхгүй.

35.22.Дараах газарт сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглоно:

35.22.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

35.22.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

35.22.3.хүмүүнлэгийн, буяны болон шашны байгууллага;

35.22.4.сонгуулийн хороод.

35.23.Энэ хуулийн 35.22.1, 35.22.2 дахь заалт нь энэ хуулийн 36.3-т үл хамаарна.

35.24.Нам, эвсэл, нэр дэвшигч нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа явуулах тохиолдолд өөрийн бэлтгэсэн болон захиалсан нийтлэл, нэвтрүүлгийн үнэн зөв, бодитой байдлыг хариуцна.

35.25.Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 35.24-т зааснаас бусад өөрийн бэлтгэсэн болон бусдын захиалгаар бэлтгэн нийтэлж, нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийтлэл, нэвтрүүлгийн үнэн зөв, бодитой байдлыг хариуцна.

35.26.Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 35.24-т заасан нийтлэл, нэвтрүүлгийг захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр нийтэлж, нэвтрүүлэх бөгөөд нийтлэл, нэвтрүүлгийн материал дээр захиалагчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичсэн байх ба энэ нь тухайн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна.

35.27.Сонгуулийн ерөнхий хороо болон тойргийн хороо сонгуулийн



сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.

35.28. Улс төрийн намын тухай хуулийн 19.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулахаар улсын төсвөөс олгосон санхүүжилтийг сонгууль товлон зарласан өдрөөс хойш сонгуулийн дүн эцэслэн гаргах хүртэл хугацаанд зарцуулахыг хориглоно.

35.29. Энэ хуулийн 35.15.1, 35.18.10-т заасныг зөрчиж сонгогчид бэлэн мөнгө, эд бараа тараасныг сонгогч баримттайгаар сонгуулийн хороонд мэдэгдсэнийг тухайн сонгуулийн хороо холбогдох байгууллагад шилжүүлэх бөгөөд уг асуудлыг холбогдох байгууллага үндэслэлтэй болохыг нь тогтоосон тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо тухайн сонгогчид бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

35.30. Иргэн нам, эвсэл, нэр дэвшигчийг энэ хуулийн 35.15.1, 35.18.10-т заасныг зөрчиж бэлэн мөнгө, эд бараа тараасан тухай хуурамч мэдээлэл тараан нам, эвсэл, нэр дэвшигчийг гүтгэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг долоогоос арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

35.31. Энэ хуулийн 35.24-т заасныг зөрчсөн бол нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиаас дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиаас дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 35.25-д заасныг зөрчсөн бол хэвлэл мэдээллийн байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

35.32. Энэ хуулийн 35.24-т заасныг зөрчсөн нь тухайн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд уг шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо нийтэд мэдээлнэ.

35.33. Энэ хуулийн 35.24, 35.25-д зааснаас бусад 35 дугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвсэл, хэвлэл мэдээллийн байгууллага болон



бусад хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, бусад этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

35.34.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасныг зөрчиж сонгогчид мөнгө, эд зүйл тараасан нь тухайн нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдож, Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэх авснаас хойш тогтоогдвол тухайн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон этгээдийн Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэхийг хэрэв тухайн этгээд нь тойргийн хороонд бүртгүүлсэн бол тойргийн хороо нь, хэрэв тухайн этгээд нь Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн бол Сонгуулийн ерөнхий хороо тус тус хүчингүй болгоно.

35.35.Энэ хуулийн 35.15-д заасныг зөрчсөн нь нэр дэвшигчийг бүртгэснээс хойш тогтоогдсон бол, эсхүл энэ хуулийн 35.18-д заасныг зөрчсөн нь нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэл болох ба энэ хуулийн 35.18.10-35.18.13-т заасныг зөрчсөн этгээдийг зохих сонгуулийн хороо нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

35.36.Энэ хуулийн 35.20-д заасныг зөрчсөн нь нэр дэвшигч, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгүүлснээс хойш тогтоогдсон бол нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болох бөгөөд уг шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо нийтэд мэдээлнэ.

35.37.Төрийн албан хаагч энэ хуулийн 35.18.16-д заасныг зөрчсөн нь түүнийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

36 дугаар зүйл.Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх

36.1.Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааныг энэ хуулийн 35.1, 35.3-т заасан хугацааны дотор хийнэ.

36.2.Тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь нам, эвсэл, нэр дэвшигчид уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж, тэгш хандах үүрэгтэй.

36.3.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 36.1-д заасан арга хэмжээнд зориулж соёлын төв, биеийн тамирын болон хурлын танхимыг төлбөргүйгээр ашиглуулна.



36.4.Энэ хуулийн 36.1-д заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 36.2-т заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 36.3-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

37 дугаар зүйл. Сонгуулийн зардал

37.1. Сонгуулийн ерөнхий хороо тойрогт нэг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоо зэргийг харгалзан тойрог тус бүрээр, түүнчлэн нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний дотор тус тус тогтооно.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасан сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээнд багтаан нам, эвслийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл нь, нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч тус тус хариуцах бөгөөд бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа өөрөө хариуцна.

37.3. Энэ хуулийн 37.1-д заасан сонгуулийн зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

38 дугаар зүйл. Сонгуулийн зардлын данс

38.1. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор тойрогт нэр дэвшигчдээс бусад нам, эвслээс нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын нэг дансыг банкинд нээлгэн, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.

38.2. Тойрогт нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшигч тус бүр

дээр, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг тойргийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор банкинд нээлгэн, Сонгуулийн ерөнхий хороо болон Үндэсний аудитын газарт бичгээр мэдэгдэж, нийтэд зарлана.

38.3.Нам, эвслийн тойрогт нэр дэвшигчдээс нам, эвслээс бусад нэр дэвшигч нь энэ хуулийн 38.1-д зааснаас өөр данс, тойрогт нэр дэвшигч нь энэ хуулийн 38.2-т зааснаас өөр данс нээлгэхийг тус тус хориглоно.

38.4.Энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зориулалтаар нь зарцуулна.

38.5.Энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд төвлөрсөн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагчийн бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

38.6.Энэ хуулийн 38.3-38.5-д заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 38.4, 38.5-д заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох ба энэ хуулийн 38.1, 38.2-т заасан данснаас гадуур өгсөн, энэ хуулийн 38.3-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно.

38.7.Энэ хуулийн 38.3, 38.4-т заасныг зөрчсөн нь нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэл болно.

39 дүгээр зүйл. Сонгуулийн хандив

39.1.Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ хувь хүнээс нэг сая төгрөг хүртэл, хуулийн этгээдээс гурван сая төгрөг хүртэл байж болно.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан хандивын хэмжээг энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн нийлбэрээр тооцно.

39.3.Хуулийн этгээдээс хандив өгөх тухай шийдвэрийг түүний эрх бүхий байгууллага гаргана.



39.4.Мөнгөн хандивыг зөвхөн энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансаар дамжуулж өгнө.

39.5.Хандивыг мөнгөн бус хэлбэрээр өгвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлж, энэ хуулийн 39.1-д заасан хандивын дүнд оруулан тооцно.

39.6.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн хандивын хэмжээ, хэлбэрийг сонгуулийн зардлын тайланд тусгана.

39.7.Дараах этгээдээс хандив авахыг хориглоно:

39.7.1.гадаад улс буюу гадаадын байгууллага /хамтарсан байгууллагын гадаадын оролцогч/;

39.7.2.олон улсын байгууллага;

39.7.3.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

39.7.4.гадаад улсын иргэн;

39.7.5.харьяалалгүй хүн;

39.7.6.сонгууль товлон зарласан өдөр арван найман нас хүрээгүй Монгол Улсын иргэн;

39.7.7.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;

39.7.8.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;

39.7.9.Үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага;

39.7.10.байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

39.8.Сонгууль зохион байгуулах хугацаанд гадаад, дотоодын тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах, худалдан борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно.

39.9.Сонгуулийн жил зөвхөн сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хандив өгөх бөгөөд энэ тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн 18.3-т заасан хандивыг нам, эвсэлд давхардуулан өгөхийг хориглоно.

39.10.Энэ хуулийн 39.1, 39.3, 39.4, 39.9-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин

нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 39.6-39.8-д заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 39.6-д заасныг зөрчсөн бие даан нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 39.7.3, 39.7.7-39.7.10-т заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 39.8-д заасныг зөрчсөн нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

39.11.Энэ хуулийн 39.1-д заасан хэмжээнээс илүү гарсан, түүнчлэн энэ хуулийн 39.7-д заасан этгээдээс авсан хандивыг хурааж, улсын орлого болгоно.

39.12.Энэ хуулийн 39.7-д заасан этгээдээс хандив авч зарцуулсан нь нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэл болно.

40 дүгээр зүйл. Сонгуулийн зардлын тайлан гаргах

40.1. Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулсан тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайланг хөтлөх журмыг Сонгуулийн ерөнхий хороо Монголбанкттай хамтран батална.

40.2. Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

40.3. Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч энэ хуулийн 40.2-т заасан сонгуулийн зардлын тайлан /цаашид "зардлын тайлан" гэх/-д аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

40.4. Зардлын тайланг дараах үзүүлэлтээр гаргана:

40.4.1. энэ хуулийн 38.1, 38.2-т заасан дансанд төвлөрүүлсэн орлого, нийт хандивын хэмжээ;



40.4.2.энэ хуулийн 40.4.1-д заасан орлогын эх үүсвэр, түүний дотор хандивын төрөл, хэмжээ;

40.4.3.хандивлагч иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хандивын хэмжээ, хэлбэр;

40.4.4.хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх захирлын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр;

40.4.5.зарлагын ангилал, гүйцэтгэл;

40.4.6.үлдэгдлийн хэмжээ, байршил.

40.5.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, энэ хуулийн 40.2-т заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

40.6.Сонгуулийн ерөнхий хороо зардлын тайланг хянаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба хоёр зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана.

40.7.Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл нам, эвсэл, нэрдэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлийг төрийн аудитын байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулна.

40.8.Энэ хуулийн 40.2-40.4-т заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 40.5-д заасныг зөрчсөн банкны захирлыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
САНАЛ АВАХ, СОНГУУЛИЙН ДҮН ГАРГАХ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ БҮРТГЭХ

41 дүгээр зүйл. Санал авах газар, хугацаа

41.1.Сонгогчдын саналыг санал авах өдрийн 07.00 цагаас 20.00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.

41.2.Хэсгийн хороо сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

41.3.Сонгогчдоос саналаа нууцаар бэлтгэхэд шаардагдах тооны бүхээг, зөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмж бүхий байрыг санал авах өдрөөс долоо хоногийн өмнө тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүлнэ.

41.4.Хэсгийн хорооны байр болон санал авах байрыг бэлтгэх заавар, санал бэлтгэх бүхээгийн хэмжээ, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

41.5.Санал авах байранд нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч байрлахыг хориглоно.

41.6.Хэсэгт саналын хуудас хүлээн авснаас хойш санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна.

41.7.Хэсгийн хороо санал авах өдрөөс 30 хоногийн өмнө хэсэг дэх санал авах байрны дугаар, нэр, хаяг, байршил, шаардлагатай бол орчин тойрны дэвсгэр /план/ зургийг баталж, нийтэд зарлан мэдээлэх ба ингэхдээ нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байхаар зохион байгуулж болно.

41.8.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчдын тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

41.9.Энэ хуулийн 41.7-д заасан санал авах байрыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдээлнэ.

41.10.Энэ хуулийн 41.3-т заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 41.5-д заасныг зөрчсөн нам, эвсэл, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, шадар туслагч, ухуулагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

42 дугаар зүйл.Саналын хуудас

42.1.Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх,



сонгуулийн дүнг гаргах үндсэн баримт бичиг мөн бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

42.1.1. агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчдод саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх;

42.1.2. сонгогч саналаа хэрхэн тэмдэглэх тухай товч заавар агуулсан байх.

42.2. Саналын хуудас нь тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэгтэй байна.

42.3. Саналын хуудас нь тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн болон нам, эвслийн нэрийг бичсэн хоёр хэсэг бүхий хуудас байна.

42.4. Саналын хуудасны тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн хэсэгт тухайн тойрогт нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийн нь нэрийг том үсгээр, нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэрийг бичнэ.

42.5. Нэр дэвшигчдийн нэрийг саналын хуудсанд бичихдээ тэдгээрийг дэвшүүлсэн намуудынх нь Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн он, сар, өдрийг баримталж, хамгийн анх бүртгүүлсэн намын нэр дэвшигчийг эхэнд нь бичих замаар дараалалд оруулан бичнэ.

42.6. Саналын хуудасны тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн хэсэгт бие даан нэр дэвшигчийн нэрийг нам, эвслээс нэр дэвшигчийн нэрийн дараа, тойргийн хороонд нэр дэвшигчээр бүртгүүлсэн дарааллаар бичнэ.

42.7. Саналын хуудасны нам, эвслийн нэрийг бичсэн хэсэгт нам, эвслийн нэрийг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн он, сар, өдрийг баримталж, хамгийн анх бүртгүүлсэн намыг эхэнд нь бичих замаар дараалалд оруулан бичнэ.

42.8. Эвслийг энэ хуулийн 42.7-д заасан дараалалд оруулахдаа эвслийн бүрэлдэхүүнд орсон намуудаас хамгийн анх Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын бүртгэлийн он, сар, өдрийг баримтална.

42.9. Саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

42.10. Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг эрхлэн хэвлүүлж, тойргийн хороонд, тойргийн хороо нь салбар хороогоор дамжуулан санал авах өдрөөс тав хоногийн өмнө хэсгийн хороонд тус тус албан ёсоор хүлээлгэн өгнө.



42.11.Сонгуулийн хороод саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж, хүлээн авахад байлцсан дарга, нарийн бичгийн дарга, бүх гишүүн гарын үсэг зурна.

42.12.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, аль нэг гишүүн энэ хуулийн 42.11-д заасан тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгаан, үндэслэлээ бичгээр үйлдэж, холбогдох сонгуулийн хороонд өгөх үүрэг хүлээнэ.

42.13.Энэ хуулийн 42.11-д заасны дагуу сонгуулийн хорооны бүрэлдэхүүний олонхи нь гарын үсэг зурсан тохиолдолд сонгуулийн хороо саналын хуудсыг хүлээн авсанд тооцно.

42.14.Энэ хуульд заасан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглоно.

42.15.Энэ хуулийн 42.12, 42.14-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

43 дугаар зүйл.Санал авах ажиллагаа

43.1.Санал авах өдрийн 07.00 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан санал тоолох төхөөрөмж, санал авах бүх хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсны дараа хэсгийн хорооны дарга дараах мэдээлэл хийнэ:

43.1.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо;

43.1.2.хүлээн авсан, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн саналын хуудасны тоо;

43.1.3.саналын хуудасны индекс дугаар.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан ажиллагаа, мэдээллийг нэг бүрчлэн тусгасан тэмдэглэл хөтөлж хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга болон бүх гишүүн гарын үсэг зурна.

43.3.Сонгуулийн ажиглагч энэ хуулийн 43.2-т заасан тэмдэглэлтэй танилцсан тухайгаа гарын үсэг зурж тэмдэглүүлж болно.



43.4.Хэсгийн хороо энэ хуулийн 43.1-43.3-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал хураалтыг эхлүүлэх ба ингэхдээ иргэний үнэмлэхийг нь сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудас олгоно.

43.5.Саналын хуудас авсан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсгээ зурж баталгаажуулна.

43.6.Санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон сонгуулийн ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

43.7.Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байхыг хориглох бөгөөд энэ нь тэдгээрээс саналаа өгөхөд хамаарахгүй.

43.8.Сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

43.9.Энэ хуулийн 43.1, 43.2, 43.4, 43.5-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 43.7-д заасныг зөрчсөн нэр дэвшигч болон иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

44 дүгээр зүйл. Сонгуулийн ажиглагч

44.1.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч өөрийн сонгуулийн ажиглагч /цаашид "ажиглагч" гэх/-ийг томилж ажиллуулна.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан ажиглагч нь санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.

44.3.Энэ хуулийн 44.2-т заасан хугацаа өнгөрсөн бол ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахгүй.

44.4.Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу



явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах бөгөөд дараах эрх эдэлнэ:

44.4.1.сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;

44.4.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах;

44.4.3.санал тоолох ажлыг ажиглах;

44.4.4.бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягттай танилцах;

44.4.5.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарьтай танилцах;

44.4.6.санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

44.4.7.санал авах байранд сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх;

44.4.8.санал авах үйл явцад зерчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах;

44.4.9.хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах;

44.4.10.ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх.

44.5.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн төлөөллийн тус бүр нэг ажиглагч хэсэгт санал хураалт дууссаны дараа санал тэмдэглэсэн тухайн хэсэг дэх саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авч болно.

44.6.Ажиглагч энэ хуулийн 44.4-т заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал, хуурамч мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж сонгуулийн хороодын ажилд хөндлөнгөөс оролцвол хэсгийн хороо түүний ажиглагчийн эрхийг хүчингүй болгож, үнэмлэхийг нь хураан авна.

44.7.Ажиглагч энэ хуулийн 44.6-д заасны дагуу эрхээ хасуулсан



бол түүнийг санал болгосон нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь орны хүнийг томилох эрхгүй бөгөөд ийм хүсэлт гаргавал сонгуулийн хороод хүлээн авахаас татгалзана.

44.8. Сонгуулийг ажиглахтай холбогдсон журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

44.9. Дотоод, гадаадын байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн явцыг ажиглах, сурвалжлахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 44.8-д заасан журмаар зохицуулна.

44.10. Энэ хуулийн 44.6-д заасныг зөрчсөн ажиглагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 44.7-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

45 дугаар зүйл. Сонгогч саналаа өгөх

45.1. Сонгогч санал авах байранд ирж, саналаа өөрөө биечлэн гаргана.

45.2. Сонгогчид дараах зүйлийг хориглоно:

45.2.1. тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох, хуурч мэхлэх;

45.2.2. тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах, эсхүл санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;

45.2.3. саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх;

45.2.4. саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусдад харуулах;

45.2.5. аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.



45.3. Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэхдээ зөвхөн энэ хуулийн 42.1.2-т заасан зааварт заасны дагуу тэмдэглэгээг хийнэ.

45.4. Сонгогч бүр саналын хуудас авч, санал бэлтгэх бүхээгт саналаа нууцаар гаргана.

45.5. Сонгогч нь саналын хуудасны тойрогт нэр дэвшигчдийн нэрийг бичсэн хэсэг дэх өөрийн дэмжиж байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн өмнөх дугаарыг тэмдэглэнэ.

45.6. Сонгогч нь саналын хуудасны нам, эвслийн нэрийг бичсэн хэсэг дэх өөрийн дэмжиж байгаа зөвхөн нэг нам, эсхүл эвслийн нэрийн өмнөх дугаарыг тэмдэглэнэ.

45.7. Сонгогч энэ хуулийн 45.5, 45.6-д заасны дагуу саналаа тэмдэглэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ.

45.8. Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэх, саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхтэй холбогдсон журмыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

45.9. Сонгогч санал өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай хуудсыг шалгуулан хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, энэ хуулийн 45.5, 45.6-д заасны дагуу саналаа гаргаж болно.

45.10. Хэсгийн хороо энэ хуулийн 45.9-д заасны дагуу хураалгасан саналын хуудсыг тэмдэглэл хөтлөн хадгална.

45.11. Санал бэлтгэх бүхээгт тухайн сонгогчоос өөр хүн байхыг хориглоно.

45.12. Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно.

45.13. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч, сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажиглагч энэ хуулийн 45.12-т заасан итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.



45.14.Хэсгийн хороо нь сонгогчийн саналаа нууцаар гаргах эрхэд халдахгүйгээр санал хураалт хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчил гарвал таслан зогсоох арга хэмжээ авна.

45.15.Санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр авна:

45.15.1.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй;

45.15.2.нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа;

45.15.3.захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан;

45.15.4.байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон.

45.16.Энэ хуулийн 45.15-д заасан хүсэлт, магадлагаа, тодорхойлолтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд хэсгийн хороо зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналыг нь авах сонгогчдын нэрийн жагсаалтыг тусад нь гаргаж, сонгогчдын нэрийн жагсаалт, санал авах чиглэл, хуваарийг хуралдаанаараа хэлэлцэн батална.

45.17.Энэ хуулийн 45.16-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтад орсон сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газрынх нь хаягаар очиж авна.

45.18.Энэ хуулийн 45.16-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авахыг хориглоно.

45.19.Хэсгийн хороо сонгогчийн энэ хуулийн 45.15-д заасны дагуу битүүмжлэн авсан саналын нууцыг чандлан хадгална.

45.20.Энэ хуулийн 45.15-д заасан сонгогчийн саналыг авахад энэ хуулийн 45.1-45.8, 45.12, 45.13-т заасан журмыг баримтална.

45.21.Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчид тухайн байгууллагын захиргаа чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор хангах үүрэгтэй.



45.22.Энэ хуулийн 45.2-т заасныг зөрчсөн иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна.

45.23.Энэ хуулийн 45.10, 45.12, 45.17-45.19-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 45.11-д заасныг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 45.21-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

46 дугаар зүйл.Санал тоолох

46.1.Хэсэгт санал тоолох ажиллагааг 20.00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

46.2.Санал тоолох бэлтгэл хангагдмагц хэсгийн хорооны дарга санал тоолох тухай зарлах ба хэсгийн хороо уг ажиллагааг дараах журмаар явуулна:

46.2.1.санал өгсөн нийт сонгогчийн тоо санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;

46.2.2.санал авахад зарцуулагдалгүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган боож битүүмжлэх;

46.2.3.энэ хуулийн 46.2.1, 46.2.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар өгсөн саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийх;

46.2.4.санал тоолж дууссаны дараа санал хураалтын дүнг хэсгийн хэмжээгээр гаргах.

46.3.Санал хураалтын дүнг дараах үзүүлэлтээр гаргана:



46.3.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тухайн хэсгийн нийт сонгогчийн тоо;

46.3.2.санал өгсөн нийт сонгогчийн тоо, үүнээс зөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал өгсөн сонгогчийн тоо;

46.3.3.хүчинтэй болон хүчингүй саналын хуудасны тоо;

46.3.4.нэр дэвшигч болон нам, эвсэл бүрийн авсан саналын тоо, хувь;

46.3.5.саналын хуудас хэвлэгдсэний дараа энэ хуульд заасан үндэслэлээр нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцсон тохиолдолд саналын хуудсанд уг нам, эвслийг дэмжиж тэмдэглэсэн бол зөвхөн тухайн нам, эвсэлд өгсөн саналын тоо, хувь;

46.3.6.саналын хуудас хэвлэгдсэний дараа энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хассан, эсхүл нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлсэн нам, эвслийг сонгуульд оролцохоор бүртгэсэн тухай шийдвэрийг хүчингүйд тооцсон тохиолдолд саналын хуудсанд уг нэр дэвшигчийг дэмжиж тэмдэглэсэн бол зөвхөн тухайн нэр дэвшигчид өгсөн саналын тоо, хувь.

46.4.Нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан саналын дүнг саналын хүчинтэй хуудсаар гаргана.

46.5.Санал авахад зарцуулсан болон зарцуулагдалгүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолно.

46.6.Санал тоолох үед энэ хуулийн 46.5-д заасан зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, санал тоолох ажилд оролцогчдоор гарын үсэг зуруулна.

46.7.Санал авахад зарцуулсан саналын хуудасны тоог санал тоолох төхөөрөмжөөс гарсан болон энэ хуулийн 46.2.2-т заасны дагуу хураагдсан саналын хуудасны нийлбэрээр тооцож гаргана.

46.8.Санал тоолох цаг болоогүй байхад санал тоолох төхөөрөмжөөр саналыг тоолуулах, санал тоолох ажиллагааг завсарлахыг хориглоно.



46.9.Саналын хуудсанд огт тэмдэглэл хийгээгүй саналын хуудсыг хүчинтэй саналын хуудагт тооцож, хэнийг ч дэмжээгүй санал гэж үзнэ.

46.10.Хэсгийн хороо хуралдаанаараа санал тоолсон дүнг хэлэлцэн шийдвэр гаргаж, уншиж сонгосны дараа хүчинтэй, хүчингүй саналын хуудсыг багцлан боож битүүмжлэн санал хураалтын дүнгийн тухай тогтоол, тэмдэглэлийг сонгуулийн бусад баримт бичгийн хамт салбар хороонд, салбар хороогүй бол тойргийн хороонд нэн даруй хүргүүлнэ.

46.11.Энэ хуулийн 46.10-т заасны дагуу битүүмжилсэн саналын хуудсыг аймаг, нийслэлийн архивт нууцын журмаар хадгалах бөгөөд битүүмжилсэн саналын хуудасны баглаа боодлыг хууль, журамд зааснаас бусад тохиолдолд задлах, устгахыг хориглоно.

46.12.Энэ хуулийн 46.1-46.9-д заасан санал тоолох журам зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гишүүнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 46.11-д заасныг зөрчсөн архивын албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

46.13.Энэ хуулийн 46.12-т заасны дагуу захиргааны хариуцлага хүлээсэн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих сонгуулийн хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

47 дугаар зүйл.Санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох

47.1.Дор дурдсан саналыг хүчингүйд тооцно:

47.1.1.энэ хуулийн 46.3.5, 46.3.6-д заасан санал;

47.1.2.тойрогт ногдсон мандатын тооноос илүү, эсхүл дутуу нэр дэвшигчийн төлөө өгсөн санал;

47.1.3.нэгээс илүү нам, эвслийн төлөө өгсөн санал.

47.2.Дор дурдсан тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно:

47.2.1.баталсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудсаар санал өгсөн;



47.2.2.сонгогчоос саналаа хэрхэн тэмдэглэх талаарх саналын хуудас дахь зааварт зааснаас өөр тэмдэглэл хийсэн.

48 дугаар зүйл.Тойрогт сонгуулийн дүн гаргах, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчийг бүртгэх

48.1.Тойргийн хороо нь салбар болон хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг энэ хуулийн 46.3-т заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг тойрогт нэр дэвшигчийн авсан санал, нам, эвслийн авсан санал гэсэн ангиллаар гаргана.

48.2.Тойргийн хороо тухайн тойрогт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор нь дараалалд оруулан жагсаалт /цаашид “А” жагсаалт” гэх/-ыг гаргах бөгөөд хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан, мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцно.

48.3.Тойрогт нэр дэвшигчдээс хэн нь ч тухайн тойрогт санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал аваагүй бол уг тойргийн дүнг тусад нь гаргана.

48.4.Тойрогт санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийн тоо тухайн тойргийн мандатын тоонд хүрээгүй бол үлдсэн мандатад дахин санал хураалт явуулна.

48.5.Энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалт дахь хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчдийг тойрогт ногдох мандатын тоогоор таслахад тухайн таслагаа дахь мандатад хуваарилагдах нэр дэвшигчдийн сонгогчдоос авсан саналын тоо нь тэнцсэн тохиолдолд тэдгээр нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулж хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

48.6.Энэ хуулийн 48.4-т заасан дахин санал хураалтад хамгийн олон санал авсан, үлдсэн мандатын тооноос хоёр дахин илүү тооны нэр дэвшигчийг оруулах бөгөөд сонгогч зөвхөн үлдсэн мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчийн төлөө санал өгнө.

48.7.Тойргийн хороо нам, эвсэлд өгсөн сонгогчдын саналын тоог нам, эвсэл бүрээр нь нэгтгэж, санал хураалтын дүнг гаргана.

48.8.Тойргийн хороо санал хураалтын дүн болон сонгуулийн дүнг гурав хоногийн дотор гарган хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргаж,

Сонгуулийн ерөнхий хороонд хоёр хоногийн дотор хүргүүлнэ.

48.9.Тойргийн хороо энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон нэр дэвшигчид Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэх олгоно.

48.10.Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал тойргийн хороо санал авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

49 дүгээр зүйл.Сонгуулийн нэгдсэн дүн гаргах, суудал хуваарилах, мэдээлэх

49.1.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу тойргийн хороодоос ирүүлсэн сонгуулийн дүнг улсын хэмжээгээр дараах байдлаар нэгтгэн гаргаж, нам, эвсэлд суудлыг хуваарилна:

49.1.1.нам, эвсэл тус бүрийн авсан нийт саналын тоог гаргаж, бүх нам, эвслийн авсан нийт саналын таваас доошгүй хувийн санал авсан нам, эвслийг авсан саналын хувиар нь дараалалд оруулан жагсаалт /цаашид "Б" жагсаалт" гэх/-ыг гаргах;

49.1.2.энэ хуулийн 49.1.1-д заасан таван хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваан "Б" жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцох;

49.1.3."Б" жагсаалтад орсон нам, эвслийн энэ хуулийн 49.1.2-т заасан саналын хувиудын нийлбэрийг 28-д хувааж нэг суудалд ногдох хувийг тооцох;

49.1.4."Б" жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн энэ хуулийн 49.1.2-т заасан саналын хувийг энэ хуулийн 49.1.3-т заасан нэг суудалд ногдох хувьд хувааж Улсын Их Хурлын гишүүний 28 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах;

Тайлбар: "Их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах" гэж нам, эвслийн авсан саналын хувьд ногдох суудлын тоог бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгтэй нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэл буюу бутархай хэсэгтэй нам, эвслээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нэмж хуваарилах замаар бүх суудлыг хуваарилж дуусгахыг ойлгоно.

49.1.5.энэ хуулийн 48.2-т заасан "А" жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын



хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид "В" жагсаалт" гэх/-ыг гаргах:

49.1.5.а.санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;

49.1.5.б.санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;

49.1.5.в.санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.

Тайлбар: Энэ хуулийн 48.5-д заасны дагуу дахин санал хураалтад орсон боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчийн "В" жагсаалт дахь өөрийн авсан саналын хувь нь анхны санал хураалтын саналын хувь байна.

49.1.6.тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан "В" жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, "В" жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа тойрогт нэр дэвшигчдээс бусад тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийг энэ хуулийн 27.5.4-т заасан жагсаалтад байгаа дарааллаар нь эрэмбэлж жагсаалт /цаашид "Г" жагсаалт" гэх/-ыг нам, эвсэл бүрээр нь гаргах;

Тайлбар: "Г" жагсаалтыг гаргах явцад нэг нам, эвслээс нэр дэвшигчдийн саналын хувь тэнцсэн тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчдийн тойрогт авсан саналын тоог үндэслэн дараалалд оруулах зарчмыг баримтална.

49.1.7.тухайн нам, эвслийн энэ хуулийн 49.1.6-д заасан "Г" жагсаалтын эхнээс уг нам, эвсэлд энэ хуулийн 49.1.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцох.

49.2.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 49.1.7-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчид Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэх олгоно.

49.3. Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийн авсан суудлын тоо, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдын нэрийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ
САНАЛ ХУРААЛТ БОЛОН СОНГУУЛИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ,
ДАХИН САНАЛ ХУРААХ, ДАХИН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ НӨХӨН СОНГОХ

50 дугаар зүйл. Хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, дахин санал хураах

50.1. Тойргийн хороо дор дурдсан тохиолдолд хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно:

50.1.1. байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авснаас бусад тохиолдолд санал хураахаар зарласнаас өөр өдөр санал авсан;

50.1.2. санал авсан саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, эсхүл хуульд заасан цагаас өмнө түүнийг нээсэн;

50.1.3. сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн буюу сонгогчид хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн.

50.2. Тойргийн хороо хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна.

50.3. Дахин санал хураалт явуулах шийдвэрийг тойргийн хороо гаргах бөгөөд уг шийдвэрт санал авах байр, өдрийг заах ба түүнийг ажлын өдөр явуулж болно.

50.4. Санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт сонгогч, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар хураасан саналыг хүчингүйд тооцсон бол уг саналын хайрцагт саналаа өгсөн сонгогчдыг дахин санал хураалтад оролцуулна.

50.5. Дахин санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.



50.6.Энэ хуулийн 50.5-д заасныг зөрчсөн ухуулагч, шадар туслагч, дэмжигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нам, эвсэл, бусад байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно.

51 дүгээр зүйл.Тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох, дахин сонгууль явуулах

51.1.Сонгуулийн ерөнхий хороо дор дурдсан тохиолдолд тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцно:

51.1.1.тойрогт нэр дэвшигчдийн хэн нь ч санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал аваагүй;

51.1.2.тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50-аас дээш хувь нь санал хураалтад оролцоогүй;

51.1.3.энэ хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу явуулсан дахин санал хураалт хүчингүй болсон бөгөөд тэр нь тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал.

51.2.Энэ хуулийн 51.1-д заасны дагуу тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцсон тохиолдолд тухайн тойрогт дахин сонгууль явуулах шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргана.

51.3.Энэ хуулийн 51.1.1-д заасны дагуу тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцож, дахин сонгууль явуулах тохиолдолд сонгогч зөвхөн тойрогт нэр дэвшигчийн төлөө санал өгнө.

51.4.Дахин сонгуулийг тухайн тойрогт сонгуулийг хүчингүйд тооцсон шийдвэр гарснаас хойш 30 хоногийн хугацаанд явуулна.

51.5.Шаардлагатай бол тойргийн болон хэсгийн хороог шинэчлэн байгуулах, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх зэрэг дахин сонгуулийг зохион байгуулах ажилд энэ хуулийн 52 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтална.

**52 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний орон гарсан
суудлыг нөхөх болон Улсын Их Хурлын
гишүүнийг нөхөн сонгох**

52.1. Тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татсан бол нөхөн сонгууль явуулна.

52.2. Энэ хуулийн 49.1.6-д заасан "Г" жагсаалтаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татсан бол Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудалд "Г" жагсаалтын тухайн нам, эвслийн дараагийн дэс дугаарт эрэмбэлэгдсэн эхний нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцох бөгөөд тухайн жагсаалтад нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явуулна.

52.3. Улсын Их Хурлын ээлжит чуулганы үеэр Улсын Их Хурлын гишүүн нас барснаас бусад тохиолдолд орон гарсан бол энэ хуулийн 52.1, 52.2-т заасан нөхөн сонгуулийг орон гарснаас хойш 14 хоногийн дотор зарлаж, 30 хоногийн хугацаанд, чуулганы бус үеэр орон гарсан бол ээлжит чуулган эхэлснээс хойш мөн хугацаанд зарлан явуулна.

52.4. Улсын Их Хурлын гишүүн нас барсан тохиолдолд уул өдрөөс хойш 50 хоногийн дотор нөхөн сонгуулийг зарлах бөгөөд энэ нь Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт тохиосон бол дараагийн Улсын Их Хурлын чуулганы эхний долоо хоногийн хуралдаанаар уг асуудлыг шийдвэрлэнэ.

52.5. Нөхөн сонгууль явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг баримтлан дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

52.5.1. хэсгийг санал авах өдрөөс 25 хоногийн өмнө, тойргийн хороог 20 хоногийн өмнө, салбар хороог 17 хоногийн өмнө, хэсгийн хороог 15 хоногийн өмнө тус тус байгуулах;

52.5.2. нэр дэвшүүлэх ажлыг нөхөн сонгууль товлон зарласан өдрөөс хойш тав хоногийн дараа эхэлж, тав хоногийн хугацаанд дуусгах;

52.5.3. энэ хуулийн 52.5.2-т заасан хугацаанаас хойш тав хоногийн хугацаанд нэр дэвшигчийг бүртгэх;



52.5.4.сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэж, санал авах өдрөөс 12 хоногийн өмнө хэсгийн хороонд өгөх;

52.5.5.хэсгийн хороо энэ хуулийн 20.11-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг тулгаж, санал авах өдрөөс арваас доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгох.

52.6.Орон гарсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол орон гарсан суудлыг нөхөхгүй.

52.7.Нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ГОМДОЛ, МАРГААН
ШИЙДВЭРЛЭХ ХАРЬАЛАЛ, ЖУРАМ**

**53 дугаар зүйл.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигчид
хүлээлгэх хариуцлага**

53.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

53.2.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

53.3.Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

53.4.Энэ хуульд заасан зөрчил гаргаж захиргааны хариуцлага хүлээсэн нь уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



54 дүгээр зүйл. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал

54.1. Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.

54.2. Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

54.3. Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал уг асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль¹⁵ болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

54.4. Энэ хуульд заасныг үндэслэн тойргийн болон салбар, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг тухайн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах тухай шийдвэрийг дээд шатных нь сонгуулийн хороо гаргах бөгөөд уг шийдвэр нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнээр ажилласан төрийн албан хаагчийг төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

55 дугаар зүйл. Хэсгийн хороо гомдол, маргааныг хүлээн авах, холбогдох арга хэмжээ авах

55.1. Хэсгийн хороо дараах гомдол, маргааныг хүлээн авч шийдвэрлэнэ:

55.1.1. энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн тухай гомдол;

55.1.2. ажиглагч энэ хуулийн 44.6-д заасан зөрчил гаргасан тухай гомдол.

¹⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



55.2.Хэсгийн хороо энэ хуулийн 55.1.1-д заасан гомдлыг улсын бүртгэлийн холбогдох байгууллагад ажлын хоёр өдрийн дотор мэдэгдэх, энэ хуулийн 55.1.2-т заасан гомдлыг ажлын хоёр өдрийн дотор, санал авах өдрийн өмнөх өдөр гомдол гаргасан бол тухайн өдөрт нь багтаан шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авна.

56 дугаар зүйл.Тойргийн хорооны хянан шийдвэрлэх гомдол, маргаан

56.1.Тойргийн хороо дараах гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:

56.1.1.энэ хуулийн 55.1-д заасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн хэсгийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол;

56.1.2.энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэсэн болон бүртгэхээс татгалзсан асуудлаар гаргасан гомдол, маргаан;

56.1.3.энэ хуулийн 35.18, 35.22-т заасан үйлдэл, үйл ажиллагаа явуулсан тухай мэдээлэл, гомдол;

56.1.4.энэ хуулийн 39.7, 39.8-д заасныг зөрчсөн тухай мэдээлэл, гомдол;

56.1.5.тойрогт нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлаар гаргасан гомдол, маргаан;

56.1.6.хэсэгт явуулсан санал хураалтын дүнг тойргийн хороо хүлээн авснаас хойш түүнтэй холбогдуулан гаргасан гомдол, маргаан.

56.2.Тойргийн хороо энэ хуулийн 56.1.1-56.1.5-д заасан гомдол, маргааныг гурван хоногийн дотор, энэ хуулийн 56.1.6-д заасан гомдол, маргааныг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

57 дугаар зүйл.Сонгуулийн ерөнхий хорооны хянан шийдвэрлэх гомдол, маргаан

57.1.Сонгуулийн ерөнхий хороо дараах гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ:

57.1.1.нам, эвслийг бүртгэсэн, түүнчлэн бүртгэхээс татгалзсантай холбогдуулан гаргасан гомдол;

57.1.2.санал хураалтын дүнг гаргасан тойргийн хорооны шийдвэр хууль зөрчсөн тухай гомдол, маргаан;

57.1.3.энэ хуульд заасан үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгэсэн болон бүртгэхээс татгалзсан асуудлаар гаргасан гомдол, маргаан;

57.1.4.нам, эвслийн тойрогт нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах асуудлаар гаргасан гомдол, маргаан;

57.1.5.энэ хуулийн 56.1-д заасан гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн тойргийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдол;

57.1.6.Сонгуулийн ерөнхий хорооны эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох гомдол, маргаан.

57.2.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 57.1.1-57.1.4-т заасан гомдол, маргааныг нэн даруй, гэхдээ хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор, энэ хуулийн 57.1.5, 57.1.6-д заасан гомдол, маргааныг нэн даруй, гэхдээ хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.

57.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 57.1-д заасан асуудлаар шийдвэр гаргана.

57.4.Сонгуулийн ерөнхий хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 57.1-д заасан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх хүртэл хугацаанд доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийг түдгэлзүүлэх эрхтэй.

58 дугаар зүйл.Сонгуулийн хороодын үйл ажиллагаатай холбогдох бусад маргааныг хянан шийдвэрлэх

58.1.Хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар гаргасан хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны



хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ БУСАД АСУУДАЛ

59 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулах

59.1. Сонгуулийн үйл ажиллагааны явцад сонгуулийн хороодын ажлыг хөнгөвчилж автоматжуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг хянан нягтлах, сонгуулийн явцын мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргах, санал тоолох ажиллагаанд хүний хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг арилгах, ажиглагчид ил тод болгох зорилгоор сонгуулийн тодорхой үе шатны ажиллагаанд холбоо, мэдээллийн техник, технологийг ашиглах асуудлыг тусгай хуулиар зохицуулна.

59.2. Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох, дүнг гаргах ажиллагаанд ашиглах холбоо, мэдээллийн техник, технологийн шийдлийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж зөвшилцөнө.

59.3. Сонгуулийн үйл ажиллагаанд холбоо, мэдээллийн техник, технологи ашиглахтай холбогдох зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал ээлжит сонгуулийн өмнөх жилийн улсын төсөвт тусган батална.

60 дугаар зүйл. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

60.1. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

61 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

61.1. Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “нэр дэвших болсон бол хуульд заасны дагуу нэр дэвшигчээр бүртгүүлэхээр сонгуулийн хороонд холбогдох баримт бичгийг ирүүлэхээс өмнө” гэснийг “нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.15-15.1.17 дахь заалт:

"15.1.15.сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах;

15.1.16.Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, сонгуулийн эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах;

15.1.17.Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;"

2/15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг:

"15.5.Үндэсний аудитын газар энэ хуулийн 15.1.17-д заасан дүгнэлтийн нэг хувийг уг дүгнэлтийг гаргаснаас хойш хоёр хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх бөгөөд уг дүгнэлтэд улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хуулбарыг хавсаргана."

2 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн



15.2.5 дахь заалтын "15.1.14," гэсний дараа "15.1.15, 15.1.16, " гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалтын дугаарыг "15.1.18." болгон өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд дор дурдсан агуулгатай 23¹ дүгээр зүйл нэмсүгэй:

**"23¹ дүгээр зүйл.Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тавигдах
шаардлага**

23¹.1.Сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тухайн нэр дэвшигчийг дэвшүүлсэн улс төрийн нам, улс төрийн намуудын сонгуулийн эвслийн Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, улсын төсвөөс санхүүжилт шаардагдах аливаа зорилтыг тусгахгүй байна.

23¹.2.Сонгуульд нэр дэвшигч нь сонгууль зохион байгуулах хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлах, сурталчилгаа явуулахыг хориглоно.



23^{1.3}.Энэ хуулийн 23^{1.1}, 23^{1.2}-т заасныг зөрчсөн нь Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэхгүй байх, бүртгэлээс хасах үндэслэл болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/82¹ дүгээр зүйл:

“82¹ дүгээр зүйл.Сонгуулийг будлиантуулж төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах

82^{1.1}.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах зорилгоор сонгуулийг зохион байгуулалттайгаар будлиантуулсан бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

82^{1.2}.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, их хэмжээний эд хөрөнгийн болон бусад хор уршиг учирсан бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:Энэ хуулийн 82^{1.1}-д заасан гэмт хэрэгт оролцохоор завдсан боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө энэ тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.”

**2/130¹ дүгээр зүйл:**

“130¹ дүгээр зүйл. Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх

130^{1.1}. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Орон нутгийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгад оролцох үед санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах зорилгоор саналын хуудас ашиглан нэгээс илүү удаа санал өгсөн, эсхүл нэгээс илүү удаа санал өгөхийг санаатайгаар зохион байгуулсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлийн 130.2 дахь хэсгийн “зэрэг аргаар үйлдсэн бол”, 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсгийн “хууль бусаар нөлөөлсөн бол” гэсний дараа “тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч,” гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

**Монгол Улсын 2012 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай,
Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай
хууль батлагдсантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.16 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/бүх шатны төсөвт байгууллагын үйл ажиллагаанд арвилан хэмнэлтийн зарчмыг баримталж, төсвийн сахилга батыг эрс сайжруулан, өр, авлага үүсгэхгүй байх, өртөг зардлыг хямдруулах, үр



ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааг бүх талаар дэмжин, байгууллагын бүтэц, орон тоог нэмэгдүүлэхгүй байх;

2/2012 оны төсвийн жилд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2011 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж дуусгасан байх;

3/хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны олон талын харилцаа /удирдлага, зохицуулалт, техник-технологийн сонголт/-ны зохицуулалтыг оновчтой болгох, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан шууд хариуцдаг байх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх_хариуцлагыг чангатгах чиглэлээр шаардлагатай хуулийн төслийг боловсруулан 2012 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/Засгийн газрын шугамаар, гадаад, дотоодын эх үүсвэрээр улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын бүртгэл, мэдээлэл, тайлагнал, бодит гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ хийх механизмыг бүрдүүлэх;

5/хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг хийж хэвших асуудлыг судлан тодорхой санал боловсруулж танилцуулах, уг судалгаа шинжилгээний ажилд Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулах арга хэмжээ авах;

6/татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулан, төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөөг биелүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

7/уул уурхайн салбарын татварын орчинд үнэлгээ хийж, татварын хууль тогтоомжийг хэрэглэхэд ойлгомжтой болгох чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

8/иргэн бүрд 1.5 сая төгрөг олгох арга хэмжээний хүрээнд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 1.0 сая төгрөгтэй тэнцэх нэрлэсэн үнэ бүхий хувьцааг иргэн бүрд эзэмшүүлэх асуудлыг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэх;

9/"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг олон улсын зах зээл дээр нээлттэй арилжиж эхлэх өдөр хүртэл хугацаанд Монгол Улсын иргэдийн эзэмшиж байгаа уг компанийн хувьцааг зөвхөн Монгол Улсын Засгийн газар нэрлэсэн үнээр нь худалдан авах, Засгийн газар үндэсний аж ахуйн нэгжүүдэд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны 10 хүртэлх хувийг нэрлэсэн үнээр санал болгож худалдах ажлыг зохион байгуулах;

10/Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд Үндэсний аудитын газраас өгч байгаа зөвлөмжийг хэрхэн тусгаж, хэрэгжүүлсэн тухай тайланг 2012 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах, төсвийн хууль зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоож, холбогдох албан тушаалтантай хариуцлага тооцох;

11/тэтгэврийн шинэчлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүн амын насжилтаас үүдэн бий болох ирээдүйн зардлыг санхүүжүүлэх зориулалтаар уул уурхайн орлогын тодорхой хувиар хуримтлалын сан байгуулахтай холбоотой хуулийн төслүүдийг боловсруулан 2012 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12/Монгол Улсад түүхий эд нь байдаг барилгын гол нэрийн бүтээгдэхүүн болох цемент, төмөр хийц зэрэг материалаар өөрийн орны өнөө ба ирээдүйн хэрэгцээг хангах, цаашид экспортлох зорилгоор үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлого, Замын-Үүдийн болон бусад гол боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулж 2012 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд гүйцэтгэлийн аудит хийхдээ 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төслүүдийг сонгон, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран иж бүрэн хяналт, шинжилгээ хийж, авах арга хэмжээний саналыг цогц байдлаар боловсруулан 2012 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Үндэсний аудитын газар /Ч.Раднаа/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Д.Хаянхярваа/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро зохистой бодлогын арга хэрэгслийг тодорхойлж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

3.Хүнсний гол хэрэглээний бараа, шатахууны хангалттай нөөцийг бүрдүүлж, нийлүүлэлтийн хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар / С.Батболд /-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Эдийн засгийн байнгын хороо /Д.Зоригт/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Н.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2011 оны
58 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2012 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Дунд, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийн орчныг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай нам, тогтвортой инфляцийн түвшинг бий болгоход мөнгөний бодлогын үндсэн зорилго оршино. Энэ зорилгын



хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлнэ.

Нэг.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2012 онд нэг оронтой тоонд, 2013-2014 онуудад найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгана.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.3.Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор Засгийн газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлнэ.

Хоёр.Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1.Эдийн засаг, санхүүгийн салбарын түргэн өсөлт, бизнесийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн банкуудын чадавхийг дээшлүүлнэ. Банкны салбарын тогтвортой байдлыг дэмжих хяналт шалгалтын олон улсын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

2.2.Банкны удирдлагыг сайжруулан үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжин, санхүүгийн хариуцлагыг өндөржүүлнэ.


2.3.Хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангана.

2.4.Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх бололцоог өргөтгөж, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

2.5.Гадаадын банкны салбар, нэгжийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гурав. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд:

3.1.Төлбөрийн карт, интернет, мобайл зэрэг бэлэн бус төлбөрийн



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.

Утас 329487